

УУЛ УУРХАЙН САЙД, БАЙГАЛЬ ОРЧИН НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2016 оны 3 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар А/28 - А/69

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар, Газрын тосны газар, Аймаг, нийслэлийн Байгаль орчны газарт тус тус үүрэг болгосугай.

УУЛ УУРХАЙН САЙД



Р.ЖИГЖИД

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД



Н.БАТЦЭРЭГ

Уул уурхайн сайд,
Байгаль орчин, ногоон хөгжил, аялал
жуулчлалын сайдын хамтарсан
2016 оны 3 дүгээр сарын 16-ны өдрийн
А/28 А/65 дугаар тушаалын хавсралт

**ГАЗРЫН ТОС, УЛАМЖЛАЛТ БУС ГАЗРЫН ТОСНЫ ЭРЭЛ, ХАЙГУУЛ,
ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨРТСӨН БАЙГАЛЬ
ОРЧНЫГ НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫН
ҮР ДҮНГ ХҮЛЭЭН АВАХ ЖУРАМ**

57 9129294 XA0017 9085084

Нэг. Зорилго

- 1.1 Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үед энэхүү журамд тодорхойлсон үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

- 2.1 Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 2 дугаар хавсралтын "Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн агуулга"-ын 2-т дурдсан "Нөхөн сэргээхтийн төлөвлөгөөний биелэлт"-тэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 2.2 Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний биелэлттэй холбогдсон харилцаа нь "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-аар зохицуулагдана.
- 2.3 Гэрээлэгч нь эрлийн гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ, тусгай зөвшөөрөл, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хувийг Аймаг, нийслэлийн байгаль орчны газарт, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайлангийн хувийг Аймаг, нийслэлийн газрын албанд тус тус хүргүүлсэн байна.
- 2.4 Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчны нөхөн сэргээлт нь Монгол Улсын Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага. MNS6200:2010 болон холбогдох бусад стандартуудын шаардлагыг хангасан байна.
- 2.5 Гэрээлэгч нь нөхөн сэргээхтийн ажлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар бүхэлд нь эсхүл хэсэгчлэн гүйцэтгүүлж болно.

**Гурав. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн үйл
ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх
ажлын үр дүнг хүлээн авах**

- 3.1 Эрлийн гэрээ байгуулсан этгээд нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлтийг эрлийн ажил эхлэхээс өмнө тухайн Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт гаргана.
- 3.2 Эрлийн гэрээ байгуулсан этгээд нь тухайн жилийн ажлын төлөвлөгөөг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар батлуулснаас хойш 15 хоногийн дотор байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.
- 3.3 Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.
- 3.4 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг тухайн жилд ажил хийх сум, дүүргийн Засаг даргад хүргүүлсэн байна.

- 3.5 Газрын тосны эрлийн үед 2 болон 3 хэмжээст чичирхийллийн судалгаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажил хийгдэх бөгөөд нөхөн сэргээлтийг байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу гүйцэтгэнэ.
- 3.6 Уламжлалт бус газрын тосны эрлийн үед 2 болон 3 хэмжээст чичирхийллийн судалгаа, өрөмдлөгийн үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажил хийгдэх бөгөөд нөхөн сэргээлтийг байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу гүйцэтгэнэ.
- 3.7 Эрлийн гэрээ байгуулсан этгээд нь нөхөн сэргээлтийн ажил дууссаны дараа тухайн сум, дүүргийн Засаг даргад үр дүнг хүлээлгэн өгөх хүсэлтийг гаргасан байна.
- 3.8 Нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг сум, дүүргийн Засаг дарга эсхүл томилогдсон албан тушаалтан хүлээн авч энэхүү журмын хүснэгт 1-ийн дагуу баталгаажуулна.

Дөрөв. Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах

- 4.1 Гэрээлэгч нь хайгуулын ажил эхлэхээс өмнө байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.
- 4.2 Гэрээлэгч нь тухайн жилийн хайгуулын ажлын төлөвлөгөөг батлуулснаас хойш 15 хоногийн дотор байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар хянуулж, тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг төсвийн хамт ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.
- 4.3 Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.
- 4.4 Гэрээлэгч нь газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлөөр хайгуулын ажил хийхгүй, үйл ажиллагаагаа түр зогсоосон тохиолдолд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайланг хойшлуулах хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх.
- 4.5 Гэрээлэгч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг тухайн жилд ажил хийх Аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлсэн байна.
- 4.6 Хайгуулын үед 2 болон 3 хэмжээст чичирхийллийн судалгаа, өрөмдлөгийн үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажил хийгдэх бөгөөд нөхөн сэргээлтийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу гүйцэтгэнэ.
- 4.7 Гэрээлэгч нь нөхөн сэргээлтийн ажил дууссаны дараа ажил хийсэн Аймаг, нийслэлийн байгаль орчны газарт үр дүнг хүлээлгэн өгөх хүсэлтийг гаргасан байна.
- 4.8 Нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг энэхүү журмын хүснэгт 1-ийн дагуу баталгаажуулна.

Тав. Газрын тос, уламжлалт бус газрын тосны олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах

- 5.1 Гэрээлэгч нь олборлолтод шилжихээс өмнө байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.
- 5.2 Гэрээлэгч нь тухайн жилийн ажлын төлөвлөгөөг батлуулснаас хойш 15 хоногийн дотор байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар хянуулж, тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг төсвийн хамт ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.
- 5.3 Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг хүлээн авсанаас хойш ажлын 15 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

- 5.4 Гэрээлэгч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг тухайн Аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлсэн байна.
- 5.5 Олборлолтын үед өрөмдлөгийн шингэн хаягдлын сан, үйлдвэрлэлийн шингэний хаягдлын сан, тусгай зориулалттай шингэний хаягдлын сангийн болон тосоор бохирдсон хөрсний нөхөн сэргээлтийн ажил хийгдэх бөгөөд нөхөн сэргээлтийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу гүйцэтгэнэ.
- 5.6 Гэрээлэгч нь нөхөн сэргээлтийн ажил дууссаны дараа тухайн Аймаг, нийслэлийн Засаг даргад үр дүнг хүлээлгэн өгөх хүсэлтийг гаргасан байна.
- 5.7 Аймаг, нийслэлийн Засаг дарга нөхөн сэргээлтийн үр дүнг хүлээн авах ажлын хэсгийг байгуулах бөгөөд уг ажлын хэсэгт Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтэс, Байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын газар, Сав газрын захиргаа, сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын төлөөлөл, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал орж энэхүү журмын хүснэгт 2-ын дагуу баталгаажуулна.

Зургаа. Бусад

- 6.1 Нөхөн сэргээлтийн үр дүнг хүлээн авахтай холбогдон гарах зардлыг гэрээлэгч бүрэн хариуцна.
- 6.2 Нөхөн сэргээлтийг дахин гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлыг өртөг нөхөгдөх зардалд тооцохгүй.

Хүснэгт 1

..... гэрээт талбайн эрэл, хайгуулын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авсан тухай баримт

1. Холбогдох мэдээлэл

Эрлийн гэрээ байгуулсан этгээд /Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгч:			
Гэрээт талбайн байршил:		Аймаг, нийслэл: Сум, дүүрэг: Баг, хороо:	
Нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэсэн хугацаа:			
Нөхөн сэргээлтийн үр дүнг хүлээлгэн өгсөн хугацаа:			
Тухайн жилийн эрэл, хайгуулын ажил		Нөхөн сэргээлтийн ажил	
Ажлын төрөл	Тоо хэмжээ /хэмжих нэгж/	Төлөвлөгөө /хэмжээ/	Гүйцэтгэл /хэмжээ/
2 хэмжээст чичирхийллийн судалгаа	Тэсэлгээ		
	Вибратор		
3 хэмжээст чичирхийллийн судалгаа	Тэсэлгээ		
	Вибратор		
Өрөмдлөг	Өрөмдлөгийн шингэний хаягдлын сан	Техникийн	
		Биологийн	

2. Нөхөн сэргээлтийн чанар, үр дүн:

.....
.....

3. Цааш анхаарах ажлууд:

.....
.....

Эрлийн ажлын үед:

.....(сум, дүүрэг)-ийн Засаг дарга.....(эсхүл томилогдсон албан тушаалтан)

Хайгуулын ажлын үед:

.....(аймаг, нийслэл)-ийн Засаг даргын томилсон албан тушаалтан

.....(аймаг, нийслэл)-ийн БОАЖГ-ын уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн

.....(аймаг, нийслэл)-ийн сум, дүүргийн иргэний төлөөлөл

Хүлээн зөвшөөрсөн:

..... Гэрээлэгчийн төлөөлөл

..... Нөхөн сэргээлт гүйцэтгэсэн компаний төлөөлөл

Хүснэгт 2

..... гэрээт талбайн олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авсан тухай баримт

1. Холбогдох мэдээлэл

Гэрээлэгч:			
Гэрээт талбайн байршил:		Аймаг, нийслэл: Сум, дүүрэг: Баг, хороо:	
Нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэсэн хугацаа:			
Нөхөн сэргээлтийн үр дүнг хүлээлгэн өгсөн хугацаа:			
Ажлын төрөл		Нөхөн сэргээлтийн ажил	
		Төлөвлөгөө /хэмжээ/	Гүйцэтгэл /хэмжээ/
Өрөмдлөгийн шингэний хаягдлын сан	Техникийн		
	Биологийн		
Үйлдвэрлэлийн шингэний хаягдлын сан	Техникийн		
	Биологийн		
Тусгай зориулалттай шингэний хаягдлын сан	Техникийн		
	Биологийн		
Тосоор бохирдсон хөрс			

2. Нөхөн сэргээлтийн чанар, үр дүн:

.....
.....

3. Цааш анхаарах ажлууд:

.....
.....

Ажлын хэсгийн дарга:

.....(аймаг, нийслэл)-ийн Засаг дарга.....(эсхүл томилогдсон албан тушаалтан)

Гишүүд:

Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын хөгжлийн бодлогын хэлтсийн төлөөлөл
 Байгаль орчны газрын төлөөлөл
 Мэргэжлийн хяналтын газрын төлөөлөл
 Сав газрын захиргааны төлөөлөл
 Сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын төлөөлөл
 Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Байгаль хамгаалагч
Газрын даамал

Хүлээн зөвшөөрсөн:

.....Гэрээлэгчийн төлөөлөл

.....Нөхөн сэргээлт гүйцэтгэсэн компаний төлөөлөл